

ВИРУСТ ХЕПАТИТ

Б.ОДХҮҮ /ЭМГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН/

- ДЭМБ-ын мэдээгээр дэлхий дахинд 325 сая хүн вируст гепатитын архаг халдвартай амьдарч байгаа бөгөөд жил бүр 1.3 сая хүн уг өвчнөөс үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдрын улмаас нас барж байна. Монгол Улсад гепатитын вирусын шалтгаантай өвчлөлийн улмаас 2017 онд 1614 хүн нас баржээ. Гепатитын В, С вирусын халдвар нь элэгний хавдрын гол шалтгаан болдог. Элэгний хорт хавдрын 80 хувь нь хожуу шатандаа оношлогдож байна. Гепатитын В, С вирусын халдварыг эрт илрүүлж, эмчлэх, элэгний хавдрыг эрт оношлох нь олон хүний амь насыг аварна хэмээн эмч мэргэжилтнүүд хэлж байна.
- 2016 оны эцсийн байдлаар дэлхий дахинд В,С вируст гепатитын архаг халдвартай нийт хүн амын 20 хүрэхгүй хувь нь оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломжтой болжээ.

- Вируст гепатит нь А, В, С, D, E вирусаар үүсгэгддэг элэгний үрэвсэл юм. Гепатитын таван вирусын халдварлах зам ялгаатай: А, E вирус халдвартай ус, хоолоор дамждаг бол гепатит В цус, биеийн шингэн, С, D вирус голдуу цусаар дамждаг. Эдгээр вирусын аль нь ч цочмог гепатит үүсгэх бололцоотой. Ихэнхи хүн цочмог халдвар аваад эдгэрдэг. Харин В, С вируст гепатит нь элэгний архаг өвчин цаашлаад элэгний хатуурал буюу цирроз, элэгний хорт хавдрыг үүсгэдэг. В вируст гепатитын дамждаг түгээмэл арга бол төрөх явцад эхээс нярайд дамжих зам юм.

С вирусын халдварлах зам

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс
 - o Баталгаагүй цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх, донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах,
 - o Ариутгаагүй багаж хэрэгслээр мэс ажилбар (гемодиализ) хийлгэх,
 - o Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс халдвар авах.
- Бусад
 - o Арьс салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулах: Гоо сайхны мэс ажилбар (чих цоолох, шивээс хийлгэх),
 - o Халдвартай хүний шүдний сойз, сахал, хумсны хутга хэрэглэх,
 - o Мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэгчид зүү, тариур дамжуулснаар, хамраар эм хэрэглэх явцад салстын бүрэн бүтэн байдал алдагдах
- Эхээс урагт дамжих нь харьцангуй цөөн (Төрөх явцад ургийн арьсны бүрэн бүтэн байдал алдагдсан) эхийн цусанд вирусийн ачаалал, АЛАТ өндөр байх нь халдвар дамжих магадлалыг ихэсгэдэг байна.
- Бэлгийн замаар халдвар дамжих: Харьцангуй түгээмэл бус ч арьс, салстын бүрэн бүтэн байдал алдагдсан үед ХСВ-ийн халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орсоноор халдвар авах боломжтой.

2.3 ХСВ-ийн халдварын эх уурхай

- ХСВ-ийн цочмог ба архаг халдвартай хүн
- ХСВ тээгч

2.2 Халдвар дамжих зам

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс
 - Баталгаагүй цус, цусан бүтээгдэхүүн, донорын эд, эрхтэн сэлбэх, шилжүүлэн суулгах,
 - Ариутгаагүй багаж хэрэгслээр (мэс ажилбар хийлгэх, гемодиализ),
 - Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс халдвар авах
- Бусад
 - Арьс салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулах гоо сайхны мэс ажилбар (чих цоолох, шивээс хийлгэх),
 - Халдвартай хүний шүдний сойз, сахлын хутга, хумсны хутга хэрэглэх,
 - Мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэгчид зүү тариур дамжуулснаар, хамраар эм хэрэглэх
- Эхээс ураг/нярайд дамжих (төрөх явцад хүүхдийн арьсны бүрэн бүтэн байдал алдагдах, эхийн цусанд вирусийн ачаалал, АЛАТ өндөр, HBeAg зэрэг байх нь халдвар дамжих магадлалыг ихэсгэдэг)
- Бэлгийн замаар халдвар дамжих: ГВВ, ГДВ-ийн халдвартай хүнтэй хамгаалалтгүй (бэлгэвчгүй) бэлгийн хавьталд орох.

2.3 ГВВ, ГДВ-ийн халдварын эх уурхай

- ГВВ-ийн цочмог эсвэл архаг халдвартай хүн
- ГДВ-ийн цочмог эсвэл архаг халдвартай хүн
- ГВВ тээгч
- ГДВ тээгч

Вируст хепатит өвчнөөс сэргийлэх арга замууд:

- А, В вируст хепатитийн халдварын эсрэг вакцин хийлгэх,
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх,
- Ундны ус, хүнсний аюулгүй байдлыг хангах,
- Цус, цусан бүтээгдэхүүний хяналт шинжилгээг сайжруулах,
- Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэг удаагийн багаж хэрэгсэл хэрэглэх,

- Шаардлагагүй тариа, эрсдэлтэй хатгалтаас зайлсхийх,
- Шивээс хийлгэх, чих цоолох зэргээр арьс, салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахаас зайлсхийх,
- Хамгаалалтгүй бэлгийн харьцаанаас татгалзах, бэлгэвч хэрэглэх.
- Вируст гепатит өвчнөөс өөрийгөө болон гэр бүл, найз нөхөд, хамт олноо хэрхэн сэргийлэх, халдвар авсан бол өвчний хүндрэл, үр дагаврыг хэрхэн бууруулах талаар ард иргэд мэдээлэл, мэдлэгтэй байх явдал уг өвчинтэй тэмцэх ажлын үндэс суурь болно.

ЭЛЭГ ГЭМТСЭН ҮЕД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ

ЯДАРЧ
СУЛЬДАХ



НОЙРМОГЛОХ



АРЬС
ЗАГАТНАХ



АРЬС ХАРЛАХ



АРЬСАН ДЭЭР
УЛААН ТОЛБО
ГАРАХ



ГЭДЭС
ЦАНХАЙХ



ГЭДЭС
ДҮҮРЭХ




ХООЛОНД
ДУРГУЙ
БОЛОХ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭЛЭГ БҮТЭН
МОНГОЛ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР



ЭЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

ЭЛЭГ БҮТЭН
МОНГОЛ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

ЭЛГЭЭ
ХАМГААЛЦГААЯ

ЭЛЭГ -НИЙ ӨВЧЛӨЛӨӨС ӨӨРИЙГӨӨ ЯАЖ ХАМГААЛАХ ВЭ?



Архи, тамхи бүү хэрэглэ



Хөгц, мөөгөнцөртэй хүнс бүү хэрэглэ



Эмийг зөвхөн эмчийн заавраар хэрэглэ



Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагаас үйлчилгээ ав



Ажил амралт, хоолны дэглэмээ зөв зохицуул



Арьс, салстын бүрэн бүтэн байдлаа хамгаалах, эрсдэлтэй тарилга, шүдний эмчилгээ, чих цоолуулах, шивээс хийлгэх, гоо сайхны мэс ажилбар хийлгэхээс зайлсхий



Тариа хийлгэхдээ нэг удаагийн тариурын бүтэн байдлыг шалгаж үзэх, заавал өөрийнхөө дэргэд задлуул, шалга



Халдвар хамгааллын дэглэм сахи



Тохиолдлын бэлгийн харьцаанаас татгалз



Сэтгэлд тааламжгүй газар хооллохоос зайлсхий




Өдөрт дор хаяж 3-5 удаа гараа угаа

ЭЛГЭЭ
ХАМГААЛЦГААЯ

Хэт өөх, тостой хоолноос татгалз

ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР 2017-2020

Монгол улсын засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолоор “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” үндэсний хөтөлбөрийг баталсан. Энэ хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжих бөгөөд Монгол улсын 15-аас дээш насны бүх хүн амд хепатит В,С вирусийн халдварыг илрүүлэх арга хэмжээг үе шатлалтайгаар зохион байгуулна.



♀ - 2976 ♂ - 3015

Статистик мэдээллээр 2016 онд 5991 элэгний хавдрын өвчлөл бүртгэгдсэн.


2017 онд 40-65 НАСНЫ ХҮН АМД

**2018 онд 15-39 НАСНЫ ХҮН АМД
65-аас дээш**

2020 он

- Элэгний С вирусийн халдвартай 150 мянган хүнийг бүрэн эмчилж эдгээнэ.
- Элэгний хорт хавдар, хатуурлын шалтгаантай нас баралтыг эрс бууруулна.
- Элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварын тархалтыг бууруулна.
- Монгол Улсын 15-аас дээш насны бүх иргэдийг (2,2 сая) элэгний В.С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна.
- С вирусийн эсрэг эмийн эмчилгээг даатгалын хөнгөлттэй үнэд багтааж сонголттойгоор олгоно.
- Элэг шилжүүлэн суулгах хагалгааны санхүүжилтийн зардлыг төр хариуцан олгоно.

ТА ЭЛЭГ НИЙ ВИРҮСИЙН ХАЛДВАРТАЙ ЭСЭХЭЭ МЭДЭЭД АВААРАЙ



**ЭЛГЭЭ
ХАМГААЛЦГААЯ**

ЭЛЭГ бол хүний биеийн “ЛАБОРАТОРИ” юм

ЭЛЭГ 1,5 КИЛОГРАММ ОРЧИМ ЖИНТЭЙ. ХҮНИЙ БИЕЙН ХАМГИЙН ТОМ ЭРХТНҮҮДИЙН НЭГ. ХОНОГТ 2000 ХҮРТЭЛ ЛИТР ЦУС ЭЛГЭЭР ДАМЖИН ӨНГӨРЧ, ХОНОГТ ЭНД ЦУСЫГ 300-400 УДАА ШҮҮДЭГ БАЙНА. ХАРШИЛ ҮҮСГЭГЧ БОДИСУУД, ХОР, ХОРТ БОДИСУУДЫГ АЮУЛГҮЙ БОЛГОЖ, БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ЯВЦАД ҮҮССЭН ИЛҮҮДЭЛ ХОРТ БОДИСУУДЫГ БИЕЭС ГАДАГШЛУУЛЖ, ЗАРИМ АМИНДЭМИЙГ (ТОСОНД УУСДАГ А, D, УСАНД УУСДАГ В12) НӨӨЦЛӨН ХАДГАЛДАГ ЮМ.

ЭЛГЭЭ
ХАМГААЛЦГААЯ

ЭЛЭГ ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?

ЦЭВЭРЛЭХ

ЭМ, ЯНЗ БҮРИЙН ХОР БОЛОН АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААГ ТАНЫ БИЕЭС ЦЭВЭРЛЭХ

НИЙЛЭГЖҮҮЛЭХ

УУРАГ ҮЙЛДВЭРЛЭСНЭЭР ХАЛДВАРТАЙ ТЭМЦЭХ ЦУС АЛДАЛТЫГ ЗОГСООХ



ЭЛЭГ

ЭЛЭГ ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ НЭГ ХЭСЭГ ЮМ. ЭЛЭГ ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭДЭГ.

ХУВИРГАХ

ИДСЭН ХООЛ, ХҮНСИЙГ УУРАГ БОЛГОН ХУВИРГАЖ, БУЛЧИНГ ТАНЫ ХӨДЛӨХӨД ТУСАЛНА

АГУУЛАХ

ЭМИЙН БОДИС, ВИТАМИН, САХАРЫГ ХАДГАЛЖ ЭНЕРГИЙГ ҮЙЛДВЭРЛЭНЭ.

ЦӨС ҮҮСГЭХ

ЦӨСНИЙ ХҮЧЛИЙН ТУСЛАМЖТАЙГААР ӨӨХ ТОСЫГ ЗАДАЛЖ, А, Д, Е, К ВИТАМИНУУДЫГ ЗОХИЦУУЛЖ, НӨӨЦӨЛНӨ.

ЭЛЭГ ГЭМТЭХ ШАЛТГААНУУД

ВИРУС

А, В, С, Д, Е

БУСАД

АРХИ, ТАМХИ, ЭМ, ХИМИЙН БОДИС, ХУРЦ ӨӨХ ТОСТОЙ ХООЛ

“ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

- 15- дээш насны сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд элэгний В, С вирүсийн шинжилгээнд 27317 хүн хамрагдсан байна. Үүнээс В вирүсийн халдвартай 2251, С вирүсийн халдвартай 2143 хүн шинжилгээгээр илэрсэн байна
- С вирүсийн идэвхжилийг тодорхойлох шинжилгээнд 1012, В вирүсийн идэвхжилийг тодорхойлох шинжилгээнд 2137 тус тус хамрагдаж, В вирүсийн эсрэг эмчилгээнд 158, С вирүсийн эсрэг эмчилгээнд 709 хүн хамрагдсан байна.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА